



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Эмэгтэйчүүдийн зөвлөлийн
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоол, 2024 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг үе шаттай шийдвэрлэх, дүүргийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, эрх тэгш байдлыг хангах чиг үүрэг бүхий Эмэгтэйчүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, зохион байгуулсан ажлын тайланг жил бүрийн эцэст дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөл (Д.Уянга)-д даалгасугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагаанд зохион байгуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (П.Баянбаатар)-нд даалгасугай.


ДАРГА



Т.УЛАМБАЯР

1159289072

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2025 оны 03 дугаар сарын 10 -ний
өдрийн 47 дугаар захирамжийн хавсралт



Эмэгтэйчүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Дарга:	Д.Уянга	Хурлын Төлөөлөгч
Гишүүд:	Ж.Чимэдцогзол	Хурлын Төлөөлөгч
	Ч.Болормаа	Хурлын Төлөөлөгч
	Б.Болортунгалаг	Хурлын Төлөөлөгч
	Ц.Амаржаргал	Хурлын Төлөөлөгч
	Э.Ганчимэг	Хурлын Төлөөлөгч
	С.Уянгазул	Хурлын Төлөөлөгч
	Э.Уянга	Хурлын Төлөөлөгч
	Ч.Хонгорзул	Хурлын Төлөөлөгч
	Ш.Нарантунгалаг	Хурлын Төлөөлөгч
Нарийн бичгийн дарга:	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн Олон нийттэй харилцах сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн	